



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 7/57

Мөрөн сум

Хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, аймгийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/32 дугаар захирамж, хөрөнгө хүлээн авах ажлын хэсгийн 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дугаар актыг үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар 2023 онд “Тамирын бугат” ХХК-ийн нийлүүлсэн 184,977,000 (Нэг зуун наян дөрвөн сая есөн зуун далан долоон мянга) төгрөгийн өртөгтэй экспортын чиг баримжаатай, импортыг орлох бүтээгдэхүүний агуулахын тоног төхөөрөмж багц-1, сэрээт өргөгч, модон хайрцаг, эвхэгддэг хуванцар хайрцаг хөрөнгүүдийг “Хөвсгөл Ус Суваг” ХХК-д эзэмшүүлж, хөрөнгийн задаргааг хавсралтаар баталсугай.

2. Хөрөнгийг эзэмшигч байгууллагад хүлээлгэн өгөх ажлыг шуурхай зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Я.Эрхэмбаяр)-д хариуцуулсугай.

3. Хуваарилагдсан хөрөнгийг байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу холбогдох дансанд бүртгэж, ҮХ-1 баримтыг Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг холбогдох байгууллагын дарга, нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын нутгийн захиргаа, аж ахуйн нэгжийн өмч хариуцсан мэргэжилтэн (А.Энхжаргал)-д даалгасугай.



Б.ДОЛЖИНСОРОГДОГ

Орон нутгийн өмчийн газрын даргын
2023 оны 12 дугаар сарын 07-ны
өдрийн А/57 дугаар тушаалын хавсралт

№	Бараа, тоног техөөрөмжийн нэр	Тоо хэмжээ	Марк, техникийн үзүүлэлт	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Сэрээт өргөгч	1	Агуулахад модон хайрцагтай төмс, хүнсний ногоог давхарлан өрөх, буулгах, ачих зориулалттай цахилгаанаар ажилладаг сэрээт өргөгч байна. Цахилгаан хөдөлгүүртэй, өргөх чадал 1000-1500 кг, ачааны радиус 500-600 мм, өргөн 1045-1070 мм, эргэлтийн радиус 1910-1990 мм, өндөр 2080 мм, урт 2240-2285 мм.	71,400,000	71,400,000
2	Модон хайрцаг	300	Хүнсний ногоо агуулахад өрж давхарлан хадгалах, тээвэрлэх зориулалттай модон хайрцаг. Урт 1-1.2 мм, өргөн 1-1.2 мм, өндөр 0.8-1.2 мм, даац 0.8-1.2 тн, сэрээ өргөгчөөр өргөх зориулалттай. 5-8 давхарлаж өрөх, 5-9 тн даацтай, багадаа 10 жилийн наслалттай. Евро стандартын мод, бат бөх, ялзарч мөөгөнцөртөхгүй, халуун хүйтэнд тэсвэртэй, агаар салхи нэвтрэх болон шороо, жижиг механик хольц унах зай завсартай, агуулахад сэрээт өргөгчөөр давхарлан хураах зориулалттай, шошго тэмдэг бэхлэх суурьтай.	348,840	104,652,000
3	Эвхэгддэг хуванцар хайрцаг	100	Хүнсний ногоо, жимсийг агуулахад өрж давхарлан хадгалах, тээвэрлэх зориулалттай модон хайрцаг. Урт 450-600 мм, өргөн 280-400 мм, өндөр 220-400 мм, эзлэхүүн 24.5-96 л. Өндөр даралтын полиэтилен, бат бөх бүтэцтэй, ялзарч мөөгөнцөртөхгүй, +35С-30С халуун хүйтэнд тэсвэртэй, агаар салхи нэвтрэх болон шороо, жижиг механик хольц унах зай завсартай, гараар өргөх нүхтэй, шошго тэмдэг	89,250	8,925,000

			бэхлэх суурьтай, ашиглахгүй үед эвхэж хураагддаг.		
Нийт дүн					184,977,000